# ХЭНТИЙ АЙМГИЙН
# НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/86 Жаргалант

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, халдваргүйтгэл, лабораторийн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5, 9.6, 9.8, 14 дүгээр зйүлийн 14.3, 14.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, халдваргүйтгэл, лабораторийн шинжилгээ хийж зохион байгуулах ажлыг 2025 оны 06 дугаар сарын 02-ноос 10 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулсугай.

2.Орон нутгийн малын өвчлөл, эпизотологийн судалгааг үндэслэн голомтот бүс нутгийн мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах, лабораторийн оношлон, тандах шинжилгээний ажлыг хариуцсан баг, өрхөд графикт хугацаанд нь зохион байгуулж ажилллахыг “Эм Тун” ХХК, “Бодь-Тара” ХХК мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч (Э.Батцэцэг), (Г.Гомбосүрэн)-д нарт үүрэг болгосугай.

3.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Багийн малчдад урьдчилан мэдэгдэж зар хүргэх, малчдын малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Шаардлагатай вакцин эм бэлдмэлийг татан авч мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангаж, тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцохыг Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (О.Банхар)-т даалгасугай.

6.Цаг үеийн мэдээ, мэдээлэл тарилгын материалыг хугацаанд нь хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Э.Батдаваа)-д даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ө.ДАВААЖАРГАЛ

232501204

Боловсруулсан
Хянасан
Хувь
Огноо

Сумын Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ний өдрийн А/86 дугаар захирамжийн хавсралт

## 2025 ОНД ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

| № | Сумын нэр | МЭҮН | Дуут хавдар (хамрагдах малын тоо) бод | Шаардлагатай вакцин (л) | Хайрцаг | Ширхэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Норовлин | Эм Тун | 2000 | 6 | 1 | 0 |
| | | Бодь-Тара | 1000 | 3 | 0 | 15 |
| Нийт дүн | | | 3000 | 9 | 1 | 15 |

| № | Сумын нэр | МЭҮН | Дотрын халдварт хордлого (хамрагдах малын тоо) бог | Шаардлагатай вакцин (л) | Хайрцаг | Ширхэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Норовлин | Эм Тун | 3000 | 21 | 2 | 24 |
| | | Бодь-Тара | 5000 | 35 | 4 | 20 |
| Нийт дүн | | | 8000 | 56 | 6 | 44 |

| № | Сумын нэр | МЭҮН | Цусан халдварт (хамрагдах малын тоо) | Шаардлагатай вакцин (л) | Хайрцаг | Ширхэг |
|---|---|---|---|---|---|---|
| | | Эм Тун | 1600 | 24 | 4 | 0 |
| | | Бодь-Тара | 400 | 6 | 1 | 0 |
| Нийт дүн | | | 2000 | 30 | 5 | 0 |